



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 23, Юу Би Эйч төв, 8 давхар,
Утас: 26 01 82

2023. 07.05 № 01/1043
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам", Эрүүл мэндийн сайдын 2023 оны 04 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ойн баярын үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг тасралтгүй хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана уу. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллах.

Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж болон хүчилтөрөгчийн үйлдвэрийн бэлэн байдлыг хангаж, тасалдал, хомсдол үүсэхгүй байх.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ойн баярын үеэр байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах.

Мөн баяр наадмын үеэр ажиллах цагийн хуваарь, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтны нэр, утасны дугаар бүхий мэдээллийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс өмнө temuulen@mmra.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хувийг: МОНГОЛЫН ЭМ ЗҮЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГДСЭН "ЭМ" ХОЛБОО, ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОО, ХҮЧИЛТӨРӨГЧИЙН ҮЙЛДВЭР, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА-д

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ЭНХТУЯА

1423 150862